

**БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

ҮНДСЭН АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ		Хуудасны дугаар
Зүйл 1	Техникийн зохицуулалтын зорилго	3
Зүйл 2	Техникийн зохицуулалтын хамрах хүрээ	3
Зүйл 3	Техникийн зохицуулалтын нэр томъёо, тодорхойлолт	4
Зүйл 4	Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ: БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТ		6
Зүйл 5	Барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн талаарх мэдээлэл	6
Зүйл 6	Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах	6
Зүйл 7	Барилгын материал, бүтээгдэхүүнийг буцаан татах	7
Зүйл 8	Барилгын материал, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэл	7
Зүйл 9	Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн үүрэг	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНД ТАВИХ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА		8
Зүйл 10	Барилгын материал, бүтээгдэхүүний хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлага	8
Зүйл 11	Барилгын материал, бүтээгдэхүүний сав баглаа, боодол, шошгололтод тавих шаардлага	9
Зүйл 12	Барилгын материал, бүтээгдэхүүн хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахаас урьдчилан сэргийлэх шаардлага	10
Зүйл 13	Барилгын материал, бүтээгдэхүүний чанараас хамаарсан аюулгүй байдалд тавих шаардлага	10
Зүйл 14	Барилгын материал, бүтээгдэхүүний, эрчим хүчний алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд тавих шаардлага	11
Зүйл 15	Барилгын материал, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүйн шаардлага	11
Зүйл 16	Импортын барилгын материал болон улсын хилээр нэвтрүүлэхэд тавих шаардлага	11
Зүйл 17	Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын үнэлгээ	13
Зүйл 18	Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаа	13
Зүйл 19	Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалт	13
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ТӨРИЙН ҮҮРЭГ, ХЯНАЛТ		15
Зүйл 20	Техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих төрийн хяналт	15
ТАВДУГААР БҮЛЭГ: ХАРИУЦЛАГА, ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА		15
Зүйл 21	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	15
Зүйл 22	Шилжилтийн журам	16
Зүйл 23	Техникийн зохицуулалтын үйлчлэх хугацаа	16
Хавсралт-1	Барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын гол шаардлагууд	

БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2024 оны сарын өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Техникийн зохицуулалтын зорилго

1.1 Энэхүү техникийн зохицуулалтын зорилго нь барилга байгууламжид барилгын материал, бүтээгдэхүүн ашиглахаас гадна үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад оршино.

- 1.1.1. Үндсэн хуулиар олгогдсон ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, амь нас, эрүүл мэндийг хамгаалах;
- 1.1.2. Иргэн, хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг хамгаалах;
- 1.1.3. Хүрээлэн буй орчны унаган төрх, ургамал, амьтны амьдрал, аюулгүй байдлыг хамгаалах түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийн үйлчлэлээс урьдчилан сэргийлэх
- 1.1.4. Худалдан авагчид, хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахаас урьдчилан сэргийлэх;
- 1.1.5. Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, нөөцийн хэмнэлтийг хангах.
- 1.1.6. Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Барилгын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Галын аюулгүй байдлын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиуд болон эдгээртэй холбогдох хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын хамрах хүрээ

2.1. Энэхүү техникийн зохицуулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл эрхлэх болон импортлох барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дахин боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, шошгололт зэрэг сүлжээний бүх үе шатны ажиллагаанаас гадна тоног төхөөрөмжийн суурилуулалт, худалдаалах, экспортлох туршилт тохируулгад хамаарна.

2.2. Энэхүү техникийн зохицуулалтаар барилгын материал, бүтээгдэхүүнд зайлшгүй тавигдах дараах шаардлагын хамгийн бага үзүүлэлтийг тогтооно.

- 2.2.1. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл явц, бүтээгдэхүүний чанар, түүний хадгалалт ба тээвэрлэлтийн аюулгүй байдлын шаардлага;
- 2.2.2. Барилгын материал, бүтээгдэхүүний чанарт тавих шаардлага;
- 2.2.3. Сав баглаа боодол ба шошгололтод тавих шаардлага;
- 2.2.4. Химийн хортой, шатамхай, галд тэсвэргүй түүхий эд, материалд тавих шаардлага;
- 2.2.5. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх шаардлага;

2.3. Энэхүү техникийн зохицуулалтаар барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын үнэлгээг тогтооно.

2.4. Энэхүү техникийн зохицуулалтад дараах зүйлүүд хамаарахгүй.

- 2.4.1. нам хүчдэлийн төхөөрөмж, цахилгаан шатны тоног төхөөрөмж болон даралтаар ажиллах төхөөрөмж;
- 2.4.2. иргэн, хуулийн этгээд зөвхөн өөрийн хэрэгцээ шаардлагадаа зориулан үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүн;
- 2.4.3. үзэсгэлэн, сурталчилгаа, шинжлэх ухааны судалгааны чиглэлээр сорьцонд дээж болгон оруулж ирсэн барилгын материал, бүтээгдэхүүн;

3 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын нэр томьёо, тодорхойлолт

3.1. Энэхүү техникийн зохицуулалтад хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1.1. **“барилгын материал”** гэж Барилгын тухай хуулийн 4.1.17-д заасан тодорхойлолтыг;

3.1.2. **“барилгын бүтээгдэхүүн”**¹ гэж эрдэс түүхий эд, барилгын материал ашиглан үйлдвэрлэлийн нөхцөлд бүтээсэн, барилга байгууламжид хэрэглэхээр зориулан үйлдвэрлэсэн эдлэхүүн, хийц бүтээц;

3.1.3. **“барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдал”**² гэж барилгын материал, бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн байгаа орчин, нийтийн болон хувийн өмч, эд хөрөнгөд хохирол учруулахгүй байхаас гадна гэнэтийн ослын үед, барилга байгууламжид ямар нэгэн гаж нөлөөлөл, эрсдэл учрахгүй байхыг;

3.1.4. **“барилгын материал, бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага”** гэж барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалтын сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн нөхцөлийг хангах бүхий л нөхцөл, үзүүлэлтийг;

3.1.5. **“барилгын материал, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээ”** гэж барилгын материалыг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;

3.1.6. **“үйлдвэрлэл эрхлэх”** гэж эрдсийн болон органик гаралтай түүхий эдийг олборлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх тэдгээрийг зах зээлд нийлүүлэхийг;

3.1.7. **“барилгын материал, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээнд ашиглах хэрэгсэл”** гэж машин техник, тоног төхөөрөмж, агуулах, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол, тавиур, улавч, чингэлэг зэрэг барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдан борлуулахад ашиглаж хэрэглэгдэх зүйлс;

3.1.8. **“хадгалах хугацаа”** гэж заасан хугацаанд зохих нөхцөлийн дагуу хадгалж, хэрэглэхэд тухайн барилгын материал, бүтээгдэхүүний нь стандартын түвшинд байх, чанарын үзүүлэлт тухайн хугацаа хэтрэхэд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдахгүй боловч чанарын үзүүлэлт нь муудах буюу өөрчлөгдөх хүртэлх хугацааг;

3.1.9. **“хэрэглэж дуусах хугацаа”** гэж тухайн барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байх, үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаа өнгөрөхөд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдах хугацааг;

3.1.10. **“барилгын материал, бүтээгдэхүүний эдэлгээний хугацаа”** гэж техникийн үйлчилгээ, барилгын материалыг бүрэн солих, их завсар хийх хүртэлх ашиглалтын шинж чанараа алдахгүй хадгалах хугацааг;

3.1.11. **“гологдол материал, бүтээгдэхүүн”** гэж барилгын материал, бүтээгдэхүүний орц найрлагад зайлшгүй орох зүйлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн

¹ MNS ISO 6707-1-2011 Барилга ба иргэний барилга байгууламжийн тайлбар толь I хэсэг ерөнхий нэр томьёо 6.1.1

² MNS ISO 6707-1-2011 Барилга ба иргэний барилга байгууламжийн тайлбар толь I хэсэг ерөнхий нэр томьёо 9.3.82

хийгээгүй, хассан, эсхүл өөр зүйлээр орлуулсан, хөлдөөх, халаах, норгох, бохирдуулах зэргээр буруу хадгалж чанараа алдсан бүтээгдэхүүний өнгө үзэмжийг засах, жин хэмжээг нэмэх, хасах зэргээр бодит байдлыг нь нуун далдалсан, өөрчилсөн материал, бүтээгдэхүүн;

3.1.12. **“барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч”³** гэж барилгын ажилд хэрэглэх материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдийг;

3.1.13. **“үйлдвэрлэлийн зохистой дадал”** гэж үйлдвэрлэлийн бүх үе шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах нөхцөл, хяналт, үйл ажиллагааг;

3.1.14. **“бүтээгдэхүүний шаардлага”** гэж баталгаажуулалтын схемийн дагуу тодорхойлсон стандарт буюу бусад норматив баримт бичигт заасан, бүтээгдэхүүнд шууд хамаарах шаардлагыг;

3.1.15. **“баталгаажуулалтын схем”** гэж нэг ижил тогтоосон шаардлага, дүрэм, журам хэрэглэх тухайн бүтээгдэхүүнд хамааралтай баталгаажуулалтын тогтолцоог;

3.1.16. **“тохирлын үнэлгээний байгууллага”** гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байгууллагыг;

3.1.17. **“итгэмжлэлийн байгууллага”** гэж тохирлын үнэлгээний үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжил чадвартайг нотлох үйл ажиллагааны итгэмжлэлийг олгох эрх бүхий байгууллагыг;

3.1.18. **“тохирлын үнэлгээний схем”** гэж тохирлын үнэлгээний тогтоосон объектод хамаарах тогтоосон нэгэн адил шаардлага, онцлог дүрэм, журам хэрэглэх тохирлын үнэлгээний тогтолцоог;

3.1.19. **“үйлдвэрлэлийн хяналтын систем”** гэж үйлдвэрлэлийн бүх үе шатанд үйлдвэрлэгчээс хэрэгжүүлдэг, түүний үндсэн шинж чанарын тогтвортой үзүүлэлт бүхий барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадварыг баталгаажуулсан цогц арга хэмжээг;

3.1.20. **“дүн шинжилгээ”** гэж сонгох болон тодорхойлох үйл ажиллагааны үр дүнд тохирлын үнэлгээ хийлгэж буй объект нь тогтоосон шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг магадлах шалгалтын ажиллагааг;

3.1.21. **“баталгааны хамрах хүрээ”** гэж баталгаанд хамрагдах тохирлын үнэлгээний объектын цар хүрээ буюу үзүүлэлтүүдийг;

3.1.22. **“баталгаажуулалт”** гэж бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үйл явц, тогтолцоо буюу ажилтанд хамаарах хөндлөнгийн дүгнэлтийг;

3.1.23. **“итгэмжлэл”** гэж тохирлын үнэлгээний байгууллагын тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжил чадвартайг нь албан ёсоор харуулсан хөндлөнгийн этгээдийн баталгаажуулалтыг;

3.1.24. **“магадлан хяналт”** гэж тохирлын баталгаажуулалтын хүчин төгөлдөр байдлыг хадгалах суурь болгож тохирлын үнэлгээний үйл ажиллагааг системтэйгээр давтан явуулахыг;

4 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зарчим

4.1. Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад дараах зарчмыг баримтална.

³ MNS ISO 6707-1-2011 Барилга ба иргэний барилга байгууламжийн тайлбар толь I хэсэг ерөнхий нэр томьёо 9.3.82

4.1.1. Барилгын материал, бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу хэрэглэхэд иргэдийн амь нас, эрүүл мэнд ба иргэн, хуулийн этгээдийн өмч, хүрээлэн байгаа орчин, ургамал, амьтны хэвийн амьдралд аюул занал учруулахгүй байхаас гадна барилга байгууламжийн ашиглалтын явцад эрчим хүчний зохистой хэрэглээг хангах, үргүй зарцуулалтыг бууруулсан байх;

4.1.2. Барилгын материал, бүтээгдэхүүн нь дагалдах баримт бичгийн шаардлагыг хангахаас гадна хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээний нөхцөлийг мөрдсөн, үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаанд өөрийн шинж чанар, үзүүлэлтээ хадгалах;

4.1.3. Барилгын материал, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шат, хадгалалт, тээвэрлэлт ба хэрэглэх нөхцөлд аюулгүйн шаардлагыг хангасан байх;

4.1.4. Барилга байгууламжийн зураг төсөл, ашиглалтын баримт бичигт тусгасан бүтээгдэхүүний ашиглалтын үед тэдгээрийн эдэлгээний хугацаа болон дагалдах баримт бичигт заасан үзүүлэлтүүдэд байнгын хяналт тавих;

4.1.5. Барилга байгууламжийн зураг төсөлд барилгын материал, бүтээгдэхүүний стандарт, норм нормативын баримт бичиг болон 1-р Хавсралтад заасан хэрэглээний тохирол, аюулгүйн шаардлагын үзүүлэлтүүдийг тусгасан байх;

4.1.6. Барилгын материал, бүтээгдэхүүн, түүний түүхий эдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, баримтад тулгуурлан тодорхойлсон байх;

4.1.7. Хяналт шалгалт нь эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, НИЙЛҮҮЛЭЛТ

5 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн талаарх мэдээлэл

5.1. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь тухайн бүтээгдэхүүний мэдээллийг маягтын дагуу цахим эсхүл цаасан хэлбэрээр хэрэглэгчдэд мэдээлнэ. Үүнд:

5.1.1. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистрийн дугаар, байршил, утас, факсын дугаар, цахим хаяг;

5.1.2. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр;

5.2. Барилгын материал бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг шинээр эрхлэгчийн хүсэлтийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч Барилгын тухай хууль болон техникийн зохицуулалтад заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган мэдээллийг цахимжуулна.

5.3. Барилгын шинэ нэр төрлийн материал, бүтээгдэхүүн нь аюулгүй байдлын үзүүлэлт, түүнийг үйлдвэрлэх, нийлүүлэх нөхцөл, шаардлагыг хангасан байна.

5.4. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэхүү техникийн зохицуулалтад заасан мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа 15 хоногийн дотор хэрэглэгчдэд цахимаар мэдэгдэнэ.

6 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлыг хангах

6.1. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ. Үүнд:

6.1.1. Барилгын материалын эрдсийн болон органик гаралтай түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээгдэхүүний анхан шатны олборлолт, боловсруулалтын зохистой дадал;

6.2. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ханган нийлүүлэгч нь үйл ажиллагаандаа түүхий эд, материалын аюулгүй байдалд нөлөөлөх аюулыг илрүүлэн тогтоох, үнэлэн дүгнэх, хянан шалгах зорилгоор дүн шинжилгээ хийж, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж болно.

7 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүнийг буцаан татах

7.1. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь түүхий эд, материал, бүтээгдэхүүнээ хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл тэдгээрийг ханган нийлүүлэлтийн сүлжээнээс буцааж татна.

7.2. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь дараах тохиолдолд салбарын хяналтын асуудал хариуцсан байгууллагын шийдвэрээр түүхий эд, материалыг борлуулалтын сүлжээнээс буцааж татна. Үүнд:

7.2.1. Барилгын материал, бүтээгдэхүүнээс шалтгаалсан хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх илрэл гарсан;

7.2.2. Тухайн түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага болон аюулгүй байдлын үзүүлэлтийг хангаагүй, бууруулсан, чанаргүй материал, бүтээгдэхүүн болохыг нь хяналт шалгалтаар тогтоосон;

7.2.3. Импорт, экспорт хийсэн барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний аюултай байдлын талаарх сэрэмжлүүлэг олон улсын мэдээллийн сүлжээгээр мэдээлэгдсэн;

7.3. Энэхүү техникийн зохицуулалтын 9.1, 9.2-т заасан үндэслэлээр барилгын материал, бүтээгдэхүүнийг буцааж татсан тохиолдолд барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэ тухайгаа холбогдох салбарын хяналтын асуудал хариуцсан байгууллага, хэрэглэгчид болон тухайн түүхий эд, материал, бүтээгдэхүүнийг хүлээн авсан дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчид нэн даруй мэдэгдэнэ.

7.4. Үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь барилгын материал, бүтээгдэхүүнийг буцааж татсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичгийг хадгална.

7.5. Үйлдвэрлэгч, нийлүүлэгч энэхүү техникийн зохицуулалтын 9.2-т заасны дагуу бүтээгдэхүүнээ буцааж татсан тохиолдолд салбарын хяналтын асуудал хариуцсан байгууллагын шийдвэрийг гартал буцааж татсан он, сар, өдрийг тэмдэглэн тухайн барилгын материал, бүтээгдэхүүнийг тусгаарлан битүүмжилж хадгална.

7.6. Хүний амь нас, эрүүл мэндэд аюултай, гарал үүсэл нь тодорхойгүй барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Хог хаягдлын тухай хуулийн хүрээнд “Татах, устгах, дахин боловсруулах тухай” журмаар зохицуулна.

7.7. Энэхүү техникийн зохицуулалтын 9.2, 9.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбогдон гарсан зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учирсан хохирлыг буруутай нь тогтоогдсон барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч хариуцна.

7.8. Салбарын хяналтыг хариуцсан байгууллага энэхүү техникийн зохицуулалтын 9.2-т заасны дагуу буцааж татсан барилгын материал, бүтээгдэхүүний талаар мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд мэдээлнэ.

8 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний гарал үүслийг тогтоох бүртгэл

8.1. Барилгын материал, бүтээгдэхүүний гарал үүслийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч өөрт хамаарах үе шатанд тогтоон, бүртгэл хөтөлнө.

8.2. Энэхүү бүртгэлийг ашиглан барилгын материал, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх эрсдэл гарсан үе шатыг тогтооно.

8.3. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэхүү техникийн зохицуулалтын 10.1-д заасан бүртгэлийн мэдээллийг материал, бүтээгдэхүүнийг хэрэглэж дуусах хугацаанаас хойш 30-аас доошгүй хоног, эсхүл хадгалах хугацаа дууссанаас хойш нэгээс доошгүй жил тус тус хадгална.

8.4. Барилгын материал, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэл хөтөлөх аргачлалыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

9 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн үүрэг

9.1. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь дараах үүргийг хүлээнэ.

9.1.1. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд энэхүү техникийн зохицуулалт болон холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлж, буруутай үйл ажиллагааныхаа улмаас учирсан хохирлыг хариуцах;

9.1.2. Энэхүү техникийн зохицуулалтын 8.1 -д заасан зохистой дадлыг үйлдвэрлэл, нийлүүлэлтийн бүх үе шатанд хэрэгжүүлэх;

9.1.3. Энэхүү техникийн зохицуулалтын 10 дугаар зүйлд заасан барилгын материал, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлийг хөтөлөх;

9.1.4. Энэхүү техникийн зохицуулалтын 9 дүгээр зүйлд заасны дагуу түүхий эд барилгын материал, бүтээгдэхүүнээ буцааж татах;

9.1.5. Үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө энэхүү техникийн зохицуулалтын 7 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэх, урьдчилсан хяналт, шалгалтад хамрагдах;

9.1.6. Барилгын материал, бүтээгдэхүүний гарал үүслийн болон дотоод хяналт, шалгалтын бүртгэл, тэмдэглэл, тайлан тооцоо, лабораторийн сорилтын дүн зэрэг мэдээлэлтэй холбоотой баримт бичгийг хадгалах;

9.2. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд дараах үйлдлийг хориглоно.

9.2.1. Барилгын материал, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт, эрүүл ахуйн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй, түүхий эд, материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;

9.2.2. Салбарын хяналтын асуудал хариуцсан байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНД ТАВИХ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

10 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлага

10.1. Барилгын материал, бүтээгдэхүүнийг дараах тохиолдолд хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй гэж үзнэ. Үүнд:

10.1.1. Барилгын материал, бүтээгдэхүүнд агуулагдах хортой бодисын агуулга болон түүнийг хэрэглэх явцад дотоод орчинд ялгарах агууламж нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн;

10.1.2. Зориулалтын бус сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласан;

10.1.3. Хадгалалтын горим зөрчиж, барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний дараагийн үе шатанд эрсдэл гаргасан;

10.1.4. Монгол Улсад болон олон улсад бүртгэгдээгүй, эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, хориглосон түүхий эд материал ашигласан;

10.1.5. Энэхүү техникийн зохицуулалтын 10 дугаар зүйлд заасны дагуу бүртгэгдээгүй химийн бодис ашиглаж үйлдвэрлэсэн;

10.1.6 Хэрэглэж дуусах хугацаа хугацаа хэтэрсэн.

10.2. Барилгын материал, бүтээгдэхүүний боловсруулалт, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах үйлдвэрлэгч, нийлүүлэгчид бүтээгдэхүүний аюулгүй байдал болон иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Олон улсын менежментийн тогтолцооны стандарт (MNS ISO 9001, MNS ISO 14001, MNS ISO 45001 гм)-ыг хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний сав баглаа, боодол, шошгололтод тавих шаардлага

11.1. Барилгын материал, бүтээгдэхүүний сав баглаа, боодол, тавиур, улавч чингэлэг нь тэдгээрийн хадгалалт, тээвэрлэлт ба борлуулалтын үед үйлдвэрлэгчийн шошгололт буюу дагалдах баримт бичигт заасан хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангасан байна.

11.2. Барилгын материалын эрдэс ба органик түүхий эд, үйлдвэрлэсэн материал, бүтээгдэхүүний эрсдлээс шалтгаалан зайлшгүй сав, баглаа боодол, хэрэглэх журмыг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

11.3. Гадаад байдлаар нь шинж чанарыг тодорхойлох боломжтой барилгын материал, бүтээгдэхүүний шаардлагатай мэдээллийг дагалдах хуудсанд тусгана.

11.4. Барилгын материал, бүтээгдэхүүний шошго дараах мэдээллийг агуулсан байна:

11.4.1. барилгын материал, бүтээгдэхүүний нэр;

11.4.2. үйлдвэрлэгчийн нэр;

11.4.3. хэмжээ, тоо ширхэг, материал, бүтээгдэхүүний цувралын дугаар;

11.4.4. үйлдвэрлэсэн он, сар, өдөр;

11.4.5. хадгалах хугацаа, эсхүл хэрэглэж дуусах хугацаа;

11.4.6. хадгалах нөхцөл;

11.4.7. орц, найрлага;

11.4.8. хэрэглэх арга;

11.4.9. гаж нөлөө, хориглох заалт.

11.5. Барилгын материал, бүтээгдэхүүний шошгон дээрх мэдээллийг Монгол хэлээр бичихээс гадна Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

11.6. Импортын барилгын материал, түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээллийг монгол, давхар англи, орос хэлний аль нэгээр орчуулж бичсэн байна.

11.7. Дараах тохиолдолд барилгын материал, бүтээгдэхүүнийг буруу хаягласан гэж үзнэ:

11.7.1. шошго нь худал мэдээлэл агуулсан;

11.7.2. тухайн материал, бүтээгдэхүүнийг өөр нэрээр бичсэн;

11.7.3. өөр нэр төрлийн материал, бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг ашиглан шошгыг дуурайлгаж хуурамчаар үйлдсэн;

11.7.4. энэхүү техникийн зохицуулалтын 13.4-т заасан шаардлагыг хангаагүй;

11.7.5. Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг шошгод тавиагүй;

11.7.6 унших боломжгүй, ойлгомжгүй үг, өгүүлбэр, он, сар, өдөр бичсэн;

11.8. Барилгын материал, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгч хариуцна.

11.9. Барилгын материал, бүтээгдэхүүний шошгод агуулагдах нэмэлт мэдээллийг олон улсын болон Монгол Улсын стандартаар зохицуулна.

11.10. Барилгын материал, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л хугацааны туршид хадгалагдах, харагдахуйц байршилд тавьсан уншихад хялбар, гаргацтай байдлаар шошголсон байна.

11.11. Барилгын материал, бүтээгдэхүүний энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын тохирол нь баталгаажаагүй бол шошголох, барилга, байгууламжид нийлүүлэхийг хориглоно.

11.12. Үйлдвэрлэгч болон нийлүүлэгч нь шошгыг барилгын материал, бүтээгдэхүүн дээр шууд тавих боломжгүй гэж үзэж байгаа тохиолдолд сав баглаа боодол дээр тавьсанаас бусад холбогдох мэдээллийг дагалдах баримт бичигт зааж өгнө.

12 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүн хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахаас урьдчилан сэргийлэх шаардлага

12.1. Худалдан авагчдыг төөрөгдөлд оруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдал, тэдгээрийн зориулалт, ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт ба хэрэглээний аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээллийг шошго хэлбэрээр, энэхүү техникийн зохицуулалтын дагуу дагалдах баримт бичигт бичвэр болон зураг байдлаар тавьсан байна.

12.2. Барилгын материал, бүтээгдэхүүн нь онцгой аюултай болохыг урьдчилан мэдээлэх тэмдгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу түүнийг ашиглах, хадгалах, тээвэрлэх, нийлүүлэх, дахин ашиглах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон сав, баглаа боодол дээрх ашиглалтын хугацааны туршид хадгалагдах нөхцөлийг хангасан байна.

12.3. Барилгын материал, бүтээгдэхүүний шошго болон тэдгээрийг дагалдах баримт бичигт худалдан авагчдыг төөрөгдөлд хүргэж болзошгүй мэдээллийн баримт бичиг зааж оруулахыг хориглоно.

13 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний чанараас хамаарсан аюулгүй байдалд тавих шаардлага

13.1. Барилгын материал, бүтээгдэхүүний чанараас хамаарсан аюулгүй байдалд тавих шаардлагыг үйлдвэрлэгч дотоод итгэмжлэгдсэн лабораторийн хяналтыг тогтмолжуулснаар хангахаас гадна энэхүү техникийн зохицуулалтын 1-р Хавсралтын дагуу хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн магадлах хяналтад тодорхой давтамжтайгаар хамруулна.

13.2. Дотоод итгэмжлэгдсэн лабораторигүй жижиг үйлдвэрлэгчид барилгын материал, бүтээгдэхүүний чанараас хамаарсан аюулгүй байдалд тавих шаардлагыг хангахдаа итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторитой гэрээний үндсэн дээр тогтмол хянуулна.

13.3. Бүтээгдэхүүний чанараас хамаарсан аюулгүй байдлын доорх шаардлагыг хангана.

а. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад тавих дотоод хяналт, шалгалт;

б. Барилга угсралтын үе шатны ажлын явцад тавих хяналт, шалгалт (гүйцэтгэгчийн);

в. Хөндлөнгийн хяналт, шалгалт (бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалт);

г. Зөвлөх эрх бүхий иргэн, хуулийн этгээд болон техникийн хяналтын байгууллагын хяналт (стандарт MNS ISO 17020);

е. Зохиогчийн хяналт.

ё. Захиалагчийн хяналт

14 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний, эрчим хүчний алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд тавих шаардлага

14.1. Барилгын ажилд хэрэглэж байгаа барилгын материал, бүтээгдэхүүн нь барилга байгууламжийн ашиглалтын явцад эрчим хүчний зохистой хэрэглээг хангасан, үр ашиггүй зарцуулалтыг бууруулахаар үйлдвэрлэгдсэн байна.

14.2. Барилгын материал, бүтээгдэхүүн нь эрчим хүчний хэрэглээтэй холбоотой баримт бичгийн шаардлагыг хангасан байна.

14.3. Барилгын материал, бүтээгдэхүүн, түүний түүхий эд нь тэдгээрийг олборлох, боловсруулах, үйлдвэрлэх, нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх ба хэрэглэх үеийн эрчим хүчний хэмнэлтийн шаардлагыг хангасан байна.

14.4. Барилга байгууламжийн угсралтын ажлын үед барилгын материал, бүтээц, бүтээгдэхүүний зураг төсөл, дагалдах баримт бичиг дэх эрчим хүчний хэрэглээний зааврыг хатуу баримтална.

15 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүйн шаардлага

15.1. Үйлдвэрлэгч нь барилгын материал, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн дагалдах баримт бичигт тухайн бүтээгдэхүүний шинж чанарын тогтоосон үзүүлэлтийг бичсэн байна.

15.2. Үйлдвэрлэгч сорил, шинжилгээний дүнг баримтжуулан гурван жил хадгална. Үйлдвэрлэгчийн баримтжуулсан мэдээлэл нь цаасан болон цахим хэлбэрээр хадгалалтын хугацааны турш үнэн зөвийн болон үл өөрчлөгдөх баталгааг хангасан байна.

15.3. Барилгын материал, бүтээгдэхүүний сорьцыг үйлдвэрлэгч нь дагалдах баримт бичигт заасан нөхцөлийн дагуу хэрэглээний шинж чанарыг бууруулахгүйгээр хадгална.

15.4. Хадгалах хугацаа дууссан барилгын материал, бүтээгдэхүүнийг энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын дагуу дахин хяналтад оруулахгүйгээр зах зээлд нийлүүлэхийг хориглоно.

16 дугаар зүйл. Импортын барилгын материал болон улсын хилээр, нэвтрүүлэхэд тавих шаардлага

16.1. Импортын барилгын материал нийлүүлэгчид бүтээгдэхүүний аюулгүй байдал болон иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх улмаар улсын хилээр нэвтрүүлэхийн тулд Олон улсын менежментийн тогтолцооны стандарт (MNS ISO 9001, MNS ISO 14001, MNS ISO 45001 гм)-ыг хэрэгжүүлнэ.

16.2. Зориулалтын бус сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласан;

16.3. Улсын хилээр нэвтрүүлэхийн өмнө хадгалалтын горим зөрчиж, нийлүүлэлтийн сүлжээний дараагийн үе шатанд эрсдэл гаргасан;

16.4. Монгол Улсад болон олон улсад бүртгэгдээгүй, хориглосон түүхий эд материал ашигласан;

16.5. Импортын барилгын материал, бүтээгдэхүүний сав баглаа, боодол, тавиур, улавч чингэлэг нь тэдгээрийн хадгалалт, тээвэрлэлт ба борлуулалтын үед үйлдвэрлэгчийн шошгололт буюу дагалдах баримт бичигт заасан хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангасан байна.

16.6. Гадаад байдлаар нь шинж чанарыг тодорхойлох боломжтой импортын барилгын материал, бүтээгдэхүүний шаардлагатай мэдээллийг дагалдах хуудсанд тусгана.

16.7. Импортын барилгын материал, бүтээгдэхүүний шошго дараах мэдээллийг агуулсан байна:

16.7.1. барилгын материал, бүтээгдэхүүний нэр;

16.7.2. үйлдвэрлэгчийн нэр;

16.7.3. хэмжээ, тоо ширхэг, материал, бүтээгдэхүүний цувралын дугаар;

16.7.4. үйлдвэрлэсэн он, сар, өдөр;

16.7.5. хадгалах хугацаа, эсхүл хэрэглэж дуусах хугацаа;

16.7.6. хадгалах нөхцөл;

16.7.7. орц, найрлага;

16.7.8. хэрэглэх арга;

16.7.9. гаж нөлөө, хориглох заалт.

16.8. Импортын барилгын материал, түүхий эд, бүтээц, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээллийг монгол, давхар англи, орос хэлний аль нэгээр орчуулж бичсэн байна.

16.9 Импортын барилгын материал, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгч хариуцна.

16.10. Импортын барилгын материал, бүтээгдэхүүний шошгод агуулагдах нэмэлт мэдээллийг олон улсын болон Монгол Улсын стандартаар зохицуулна.

16.11. Импортын барилгын материал, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л хугацааны туршид хадгалагдах, харагдахуйц байршилд тавьсан уншихад хялбар, гаргацтай байдлаар шошголсон байна.

16.12. Импортын барилгын материал нийлүүлэгч нь шошгыг барилгын материал, бүтээгдэхүүн дээр шууд тавих боломжгүй гэж үзэж байгаа тохиолдолд сав баглаа боодол дээр тавьсанаас бусад холбогдох мэдээллийг дагалдах баримт бичигт зааж өгнө.

16.13. Импортын барилгын материал, бүтээгдэхүүний шошго болон тэдгээрийг дагалдах баримт бичигт худалдан авагчдыг төөрөгдөлд хүргэж болзошгүй мэдээллийн баримт бичиг зааж оруулахыг хориглоно.

16.14. Импортын барилгын материал, бүтээгдэхүүний чанараас хамаарсан аюулгүй байдалд тавих шаардлагыг ханган нийлүүлэгч Гаалийн болон чөлөөт бүсэд байрлах ирпортын барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторийн хяналтыг тогтмолжуулснаар хангахаас гадна энэхүү техникийн зохицуулалтын 1-р Хавсралтын дагуу хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн магадлах хяналтад хамруулна

16.15. Ханган нийлүүлэгч нь барилгын материал, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн дагалдах баримт бичигт тухайн бүтээгдэхүүний шинж чанарын тогтоосон үзүүлэлтийг бичсэн байна.

16.16. Импортын барилгын материал, бүтээгдэхүүний сорьцыг ханган нийлүүлэгч нь дагалдах баримт бичигт заасан нөхцөлийн дагуу хэрэглээний шинж чанарыг бууруулахгүйгээр хадгална.

16.17. Хадгалах хугацаа дууссан барилгын материал, бүтээгдэхүүнийг энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын дагуу дахин хяналтанд оруулахгүйгээр зах зээлд нийлүүлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын үнэлгээ

17.1. Засгийн газраас баталсан Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад орсон барилгын материал, бүтээгдэхүүн нь хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахгүй байх шаардлагыг хангасан байна.

17.2. Жагсаалтад ороогүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь аж ахуйн нэгж, байгууллага, хэрэглэгчийн хүсэлтээр сайн дурын үндсэн дээр тохирлын үнэлгээнд хамруулж болно.

18 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаа

18.1. Тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна. Барилгын материал, бүтээгдэхүүнд энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын дагуу заавал хийх баталгаажуулалтын мэдүүлэгч нь тэдгээрийн үйлдвэрлэгчид буюу гадаадын үйлдвэрлэгчдийн албан ёсны борлуулагч этгээд байж болно.

18.2. Үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь “Нийлүүлэгчийн мэдэгдэл” гаргаж болно.

- энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын дагуу тохирлын тухай нийлүүлэгчийн мэдэгдлийг хүлээн авах;

- нийлүүлэгчийн мэдэгдэл нь тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

18.3. Барилгын материал, бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг баримтлан тохирлын гэрчилгээг олгоно.

18.4. Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсад болон Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна.

18.5. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн салбарын төрийн захиргааны байгууллага нь аюулгүйн тэмдэг олгох тохирлын үнэлгээний ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагыг тогтоож аюулгүйн тэмдэг олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлнэ.

18.6. “Аюулгүйн тэмдэг”-тэй бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд давтан хамруулахгүй.

19 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалт

19.1. Барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтыг Стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Монгол Улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-ын дагуу хийнэ. Баталгаажуулалтын үйл явц нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ.

19.1.1. Сонголт

- Хүсэлт гаргагчийн хүсэлтийг өргөдөл, баримт бичгийн хамт хүлээн авах;
- Бүртгэх, баталгаажуулалтын шинжээчид хуваарилах, баримт бичигт дүн шинжилгээ хийх;
- Баримт бичгийг бүрдүүлэх, нэмэлт баримт бичиг цуглуулах;

19.1.2. Тодорхойлолт

- Ирүүлсэн баримт бичигт үнэлгээ хийх, хүсэлт гаргагч үйлдвэрлэгчид мэдэгдэх, гэрээ байгуулах, үнэлгээний бэлтгэл хангах, тухайн бүтээгдэхүүнд схем сонгох, үнэлгээний удирдамж гаргах батлуулах;
- Баталгаажуулалтын болон техникийн шинжээч /байгууллага/-ийг сонгох, шударга байдлын мэдэгдэл гаргах, гэрээ байгуулах;
- Тохирлын үнэлгээ явуулах шалгуур үзүүлэлтийг холбогдох стандартын дагуу гаргах, үнэлгээ хийх шийдвэр гаргах;

19.1.3. Дүн шинжилгээ

- Бүтээгдэхүүн нь заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох, тодорхойлох ажиллагааны үе шатанд гарган авсан нотолгоог шалгах, баримт бичгийг үнэлэх, нэгтгэх;
- Үйлдвэрлэлийн үнэлгээ /газар дээрх/ явуулах, дээж авах /дээжийг үйлдвэрлэгчээс, зах зээлээс, хэрэглэгчээс, нийлүүлэгчээс авна/ сорилт туршилтад хамруулах /итгэмжлэгдсэн лабораторит/;
- Үйлдвэрлэл нь стандарт, норматив техникийн баримт бичгээр тогтоосон шаардлага хангаж байгааг үнэлэн тогтоох, үнэлгээгээр менежментийн тогтолцоо, чанарын дотоод хяналт, бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн горимын, түүхий эдийн хяналт гарал үүсэл, хэмжих багаж хэрэгслийн хяналт, лалт, шошгын хяналт, хүний нөөц, ажилтны ур чадвар, мэргэшсэн байдалд үнэлэлт өгөх, үл тохирлын хяналт залруулалт, мэргэжлийн байгууллагаас үйлдвэрлэгчид олгосон ажлын байр эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, байгаль орчны үнэлгээ;
- Хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн дунд санал асуулга явуулах;
- Ажлын хэсгийн дүгнэлт, санал /баталгаажуулалт олгох, сунгах, хүрээг өргөтгөх, багасгах, түдгэлзүүлэх, цуцлах/ гаргах;
- Үнэлгээний тайлан бэлтгэх, баримтжуулах, танилцуулах /тайланд хүчин төгөлдөр норматив нормативын баримт бичгийг ашиглана/;

19.1.4. Баталгаажуулалтын шийдвэр гаргах

- Баталгаажуулалтын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах /баталгаажуулалт олгох, сунгах, хүрээг өргөтгөх, багасгах, түдгэлзүүлэх, цуцлах/;
- Гэрээ байгуулах, гэрчилгээжүүлэх, бүртгэлжүүлэх;

19.1.5. Магадлах хяналт

- Магадлах хяналт, үнэлгээг схемд багтсан тохиолдолд явуулах;
- Магадлах хяналтыг үйлдвэрлэлийн тогтвортой байдал, менежментийн тогтоцоотой эсэх, баталгаажуулсан бүтээгдэхүүний талаарх мэдээлэлийг үндэслэх ба чанар хангах тогтолцоог үнэлэх;
- Дээж авах /тодорхой давтамжтайгаар үйлдвэрлэгчээс, зах зээлээс, хэрэглэгчээс, нийлүүлэгчээс авах/;
- Хэрэглэгч үйлчлүүлэгчдийн дунд санал асуулга явуулах;
- Магадлах хяналтаар бүтээгдэхүүний холбогдох норматив баримт бичиг өөрчлөгдсөн, дотоод хяналт, бүтээгдэхүүний сорилтын арга, чанар хангах тогтолцоонд тавих шаардлагад өөрчлөлт орсон эсвэл шаардлага биелэгдээгүй үл тохирох байдалд хүрсэн байвал гэрчилгээг хүчингүй болгох санал гаргах;
- Магадлах хяналтын үр дүнг баримтжуулан шийдвэр гаргах;

19.2. Баталгаажуулалтад хүчин төгөлдөр стандарт, норматив нормативын баримт бичгийг ашиглана.

19.3. “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д заасан барилгын материал, бүтээгдэхүүнийг импортлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тохирлын баталгаанд заавал хамруулна.

19.4. Гэрээ хэлэлцээрээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрсөн тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг гэрчилгээтэй, хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, импортоор оруулахад хяналт, тохирлын баталгаанд давтан хамруулахгүй.

19.5. Импортын барилгын материалын тохирлын баталгаажуулалтыг “Монгол Улсад бүтээгдэхүүн ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам”-ыг баримтлан явуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ТӨРИЙН ҮҮРЭГ, ХЯНАЛТ

20 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын хэрэгжилтэд тавих төрийн хяналт

20.1. Барилгын ажилд барилгын материал, бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад энэхүү техникийн зохицуулалтын шаардлагын хэрэгжилтэд тавих хяналтыг хуульд заасан хяналт, шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон холбогдох байгууллага гүйцэтгэнэ.

20.2. Үндэсний болон гадаадын үйлдвэрлэгчийн үйлдвэрлэн нийлүүлж байгаа бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтын шаардлагыг хангаагүйн хариуцлагыг үйлдвэрлэгчид, нийлүүлэгчид хүлээлгэнэ.

20.3. Салбарын хяналтын асуудал хариуцсан байгууллага нь барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын байцаагчтай байна.

20.4. Барилгын материалын эрдэс болон органик түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд дараах байдлаар хяналт тавина:

20.4.1. Барилгын материалын нийлүүлэлтийн сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс, барилга байгууламж, ажлын байр нь эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг шалгалт хийх;

20.4.2. Импортын болон дотоодод үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнд холбогдох техникийн нөхцөл, эрүүл ахуй, бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох, эрсдэлд суурилсан тандалтыг зохион байгуулах;

20.4.3. Барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж, зохих өөрчлөлт, хөдөлгөөн хийх талаар төрийн, төрийн бус байгууллага болон хэрэглэгчид шаардлагатай мэдээ, мэдээлэл өгөх;

20.4.4. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах, лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Барилгын материалын шинжилгээ судалгааны төв лаборатори байгуулан ажиллана.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА, ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1. Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын

байцаагч нь Барилгын тухай, Зөрчлийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудын холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

21.2. Энэ техникийн зохицуулалтад тусгагдсан зөрчлүүдийг давтан гаргасан этгээдийн үйл ажиллагааг нь зогсоох буюу зөвшөөрлийг хүчингүй болгоно.

21.3. Энэ техникийн зохицуулалтын дагуу захиргааны шийтгэл ногдуулсан нь буруутай этгээдийг учруулсан хохирлоо нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

22 дугаар зүйл. Шилжилтийн журам

22.1. Энэхүү техникийн зохицуулалтын үйлчлэл нь түүний хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө үйлдвэрлэгдсэн болон энэхүү техникийн зохицуулалт үйлчилж эхлэх хүртэлх хугацаанд тохирлын үнэлгээнд ороогүй барилгын материал, бүтээгдэхүүнд хамаарна.

22.2. Энэхүү техникийн зохицуулалтыг үйлчилж эхлэхээс өмнө Монгол Улсын нутаг дэвсгэр дээр барилгын материал, бүтээгдэхүүнд олгосон тохирлын гэрчилгээний үйлчлэлийн хугацааг дуусах хүртэл хүчинтэйд тооцно.

23 дугаар зүйл. Техникийн зохицуулалтын үйлчлэх хугацаа

23.1. Энэхүү техникийн зохицуулалт нь батлагдаж, түүнийг албан ёсоор хэвлэн нийтэлсэн өдрөөс хойш 8 сарын дараа хүчин төгөлдөр үйлчилнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГОЛ ШААРДЛАГУУД

Энэхүү техникийн зохицуулалтад дараах норматив баримт бичгийг ашигласан бөгөөд батлагдсан хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хувилбарыг цаашид хэрэглэнэ.

№	БТКУС-ын код	Бүтээгдэхүүний төрөл	Тухайн материалын нэр	Чанар, аюулгүй байдлын гол шаардлагууд															
1		2	4	5															
1	2517.10.00	Дүүргэгч материал	Барилгын ажилд хэрэглэх хайрга, буталсан хайрга. Техникийн ерөнхий шаардлага	<p>1. Хайрга, буталсан хайрганы ширхэгийн бүрэлдэхүүн</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">Үзүүлэлтийн нэр</th> <th rowspan="2">Хамгийн бага ширхэгийн хэмжээ /d/</th> <th colspan="2">0,5 / D + d /</th> <th rowspan="2">Хамгийн том ширхэгийн хэмжээ /D/</th> <th rowspan="2">1.25D</th> </tr> <tr> <th>Ширхэгээр ангилсан бол</th> <th>Холимог ширхэглэл тэй</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Эзлэх жингийн хувь, нийлбэр үлдэцээр</td> <td>95-100</td> <td>40-70</td> <td>50-70</td> <td>0-5</td> <td>0</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлтийн нэр	Хамгийн бага ширхэгийн хэмжээ /d/	0,5 / D + d /		Хамгийн том ширхэгийн хэмжээ /D/	1.25D	Ширхэгээр ангилсан бол	Холимог ширхэглэл тэй	Эзлэх жингийн хувь, нийлбэр үлдэцээр	95-100	40-70	50-70	0-5	0	
				Үзүүлэлтийн нэр			Хамгийн бага ширхэгийн хэмжээ /d/	0,5 / D + d /			Хамгийн том ширхэгийн хэмжээ /D/	1.25D							
					Ширхэгээр ангилсан бол	Холимог ширхэглэл тэй													
				Эзлэх жингийн хувь, нийлбэр үлдэцээр	95-100	40-70	50-70	0-5	0										
				<p>2. Ширхэгийн хэлбэр</p> <table border="1"> <thead> <tr> <th>Ширхэгийн хэлбэрийн ангилал</th> <th>Нимгэн, үзүүрлэг, шовх хэлбэртэй ширхэгийн эзлэх хэмжээ, жингийн %-аар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шоо хэлбэрийн Сайжруулсан Ердийн</td> <td>15-аас бага 15-25 хүртэл 25-35 хүртэл</td> </tr> </tbody> </table>	Ширхэгийн хэлбэрийн ангилал	Нимгэн, үзүүрлэг, шовх хэлбэртэй ширхэгийн эзлэх хэмжээ, жингийн %-аар	Шоо хэлбэрийн Сайжруулсан Ердийн	15-аас бага 15-25 хүртэл 25-35 хүртэл											
				Ширхэгийн хэлбэрийн ангилал	Нимгэн, үзүүрлэг, шовх хэлбэртэй ширхэгийн эзлэх хэмжээ, жингийн %-аар														
				Шоо хэлбэрийн Сайжруулсан Ердийн	15-аас бага 15-25 хүртэл 25-35 хүртэл														
				<p>3. Бат бэх</p> <table border="1"> <thead> <tr> <th>Бутлалтын /бат бэх/-ын марк</th> <th>Туршилтын дараах жингийн хорогдол, %-иар</th> <th>Бутлалтын маркаар шилжүүлсэн чулуулгын бат бэх, кг/см²</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Б - 8</td> <td>8 хүртэл</td> <td>1000-аас их</td> </tr> <tr> <td>Б - 12</td> <td>8-аас 12 хүртэл</td> <td>800 -аас 1000 хүтэл</td> </tr> <tr> <td>Б - 16</td> <td>12 -оос 16 хүртэл</td> <td>600 -аас 800 хүтэл</td> </tr> <tr> <td>Б - 24</td> <td>16 -аас 24 хүртэл</td> <td>400 -аас 600 хүртэл</td> </tr> </tbody> </table>	Бутлалтын /бат бэх/-ын марк	Туршилтын дараах жингийн хорогдол, %-иар	Бутлалтын маркаар шилжүүлсэн чулуулгын бат бэх, кг/см ²	Б - 8	8 хүртэл	1000-аас их	Б - 12	8-аас 12 хүртэл	800 -аас 1000 хүтэл	Б - 16	12 -оос 16 хүртэл	600 -аас 800 хүтэл	Б - 24	16 -аас 24 хүртэл	400 -аас 600 хүртэл
				Бутлалтын /бат бэх/-ын марк	Туршилтын дараах жингийн хорогдол, %-иар	Бутлалтын маркаар шилжүүлсэн чулуулгын бат бэх, кг/см ²													
				Б - 8	8 хүртэл	1000-аас их													
Б - 12	8-аас 12 хүртэл	800 -аас 1000 хүтэл																	
Б - 16	12 -оос 16 хүртэл	600 -аас 800 хүтэл																	
Б - 24	16 -аас 24 хүртэл	400 -аас 600 хүртэл																	
<p>4. Элэгдэлт</p> <table border="1"> <thead> <tr> <th>Элэгдэлтээр тогтоох марк</th> <th>Туршилтын дараах жингийн хорогдол, %-иар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Э - I</td> <td>20 хүртэл</td> </tr> </tbody> </table>	Элэгдэлтээр тогтоох марк	Туршилтын дараах жингийн хорогдол, %-иар	Э - I	20 хүртэл															
Элэгдэлтээр тогтоох марк	Туршилтын дараах жингийн хорогдол, %-иар																		
Э - I	20 хүртэл																		

				Э – II Э – III Э – IV	20-оос 30 хүртэл 30-аас 40 хүртэл 40-өөс 50 хүртэл			
5. Хүйтэн тэсвэрлэлт								
		Үзүүлэлт, хүйтэн тэсвэрлэлтийн маркаар, /ХТ/						
Туршилтын төрөл		ХТ-15	ХТ-25	ХТ-50	ХТ-100	ХТ-150	ХТ-200	ХТ-300
1. Шууд хөлдөөх аргаар								
а. Мөчлөгийн тоо		15	25	50	100	150	200	300
б. Туршилтын дараах жингийн хорогдол, %-аас ихгүй		10	10	5	5	5	5	5
2. Хүхэр хүчлийн натрийн уусмалд туршихад		3	5	10	10	15	15	15
А. Мөчлөгийн тоо		10	10	10	5	5	3	1
Б. Туршилтын дараах жингийн хорогдол, %-иас ихгүй								
6. Бохирдолт								
Хайрга, буталсан хайрганы бутлалтын марк					Б - 8	Б - 12	Б - 16	Б - 24
1. Угаах аргаар тодорхойлсон тоос, шавар, шорооны хольц, жингийн %-аас ихгүй					1,0	1,0	1,0	1,0
2. Үүний дотор цул шаврын агуулагдах хэмжээ, жингийн %-аас ихгүй					0,25	0,25	0,25	0,5

	2517.10.00		Хүнд бетонд хэрэглэх дүүргэгч материал. Техникийн шаардлага	<p>1. Бетон хольц бэлтгэхэд хайрга, буталсан хайрга, дайргыг ширхэглэлээр ялган хэрэглэх үед дараах ширхэглэлээр ангилна. Үүнд: 5-аас 10 мм хүртэл , 10-аас 20мм хүртэл, 20-иос 40мм хүртэл, 40-өөс 70мм хүртэл “ТАЙЛБАР”: 1.Хэрэглэгч, нийлүүлэгч байгууллагууд харилцан тохиролцож 5-10 мм-ийн ширхэглэлийн оронд 3-10 мм, эсвэл 5-15 мм ширхэглэлтэйг, 10-20мм-ийн ширхэглэлийн оронд 10-15мм, эсвэл 15-20мм-ийн ширхэглэлтэйг мөн 70 мм-ээс том ширхэглэлтэйгээр нийлүүлж хэрэглэхийг зөвшөөрнө</p> <p>2. Хайрга, буталсан хайрга, дайрганд агуулагдах нимгэн, үзүүрлэг хэлбэртэй ширхэгийн хэмжээ жингийн 15 хувиас ихгүй байна.</p> <p>3. Дайргыг цилиндрт шахах аргаар тодорхойлсон бат бэхийн марк нь хэрэглэх бетоны маркаас дор зааснаас багагүй байна. Үүнд: М300-аа доош маркийн бетонд 1,5 дахинаас М300 ба түүнээс дээш маркийн бетонд 2,0 дахинаас</p> <p>4. Хайрга, буталсан хайргыг цилиндрт шахах аргаар тодорхойлсон бат бэхийн марк нь хүснэгтийн шаардлагыг хангасан байна.</p> <table border="1" data-bbox="875 651 2024 810"> <tr> <th>Хэрэглэх бетоны марк(анги)</th> <th>Цилиндрт шахах аргаар тодорхойлсон хайрга, буталсан хайрганы марк</th> </tr> <tr> <td>М400(В30) ба түүнээс дээш</td> <td>Б-8 аас ихгүй</td> </tr> <tr> <td>М300-М400 (В22.5-В30)</td> <td>Б-12 аас ихгүй</td> </tr> <tr> <td>М300 (В22.5)-аас доош</td> <td>Б-16 аас ихгүй</td> </tr> </table> <p>5. Хайрга, буталсан хайрга, дайрганы тоос, шаварлаг хольцийг угаах аргаар тодорхойлоход хүснэгтийн шаардлагаас хэтрэхгүй байхаас гадна цул шаврын агуулагдах хэмжээ жингийн 0,25 хувиас ихгүй байна.</p> <table border="1" data-bbox="875 935 2024 1126"> <tr> <th rowspan="2">Дүүргэгчийн төрөл</th> <th colspan="2">Угаах аргаар тодорхойлсон тоос, шаварлаг хольцийн хэмжээ, жингийн хувиар</th> </tr> <tr> <th>М300(В22.5)-аас бага маркийн бетонд</th> <th>М300(В25) ба түүнээс дээш маркийн бетонд</th> </tr> <tr> <td>Дайрга</td> <td>2</td> <td>1</td> </tr> <tr> <td>Хайрга, буталсан хайрга</td> <td>1</td> <td>1</td> </tr> </table> <p>6. Бетонд хэрэглэх элсний ширхэгийн бүрэлдэхүүн нь хүснэгт буюу энэ стандартын 1 дүгээр зурагт заасан хязгаарт байвал зохино</p> <table border="1" data-bbox="875 1219 2024 1437"> <tr> <th>Шигшүүрийн нүхний хэмжээ, мм</th> <th>Шигшүүр дээрхи нийлбэр үлдэц, жингийн хувиар</th> </tr> <tr> <td>5</td> <td>0</td> </tr> <tr> <td>2,5</td> <td>0-20</td> </tr> <tr> <td>1,25</td> <td>15-45</td> </tr> <tr> <td>0,63</td> <td>35-70</td> </tr> <tr> <td>0,315</td> <td>70-90</td> </tr> </table>	Хэрэглэх бетоны марк(анги)	Цилиндрт шахах аргаар тодорхойлсон хайрга, буталсан хайрганы марк	М400(В30) ба түүнээс дээш	Б-8 аас ихгүй	М300-М400 (В22.5-В30)	Б-12 аас ихгүй	М300 (В22.5)-аас доош	Б-16 аас ихгүй	Дүүргэгчийн төрөл	Угаах аргаар тодорхойлсон тоос, шаварлаг хольцийн хэмжээ, жингийн хувиар		М300(В22.5)-аас бага маркийн бетонд	М300(В25) ба түүнээс дээш маркийн бетонд	Дайрга	2	1	Хайрга, буталсан хайрга	1	1	Шигшүүрийн нүхний хэмжээ, мм	Шигшүүр дээрхи нийлбэр үлдэц, жингийн хувиар	5	0	2,5	0-20	1,25	15-45	0,63	35-70	0,315	70-90
Хэрэглэх бетоны марк(анги)	Цилиндрт шахах аргаар тодорхойлсон хайрга, буталсан хайрганы марк																																		
М400(В30) ба түүнээс дээш	Б-8 аас ихгүй																																		
М300-М400 (В22.5-В30)	Б-12 аас ихгүй																																		
М300 (В22.5)-аас доош	Б-16 аас ихгүй																																		
Дүүргэгчийн төрөл	Угаах аргаар тодорхойлсон тоос, шаварлаг хольцийн хэмжээ, жингийн хувиар																																		
	М300(В22.5)-аас бага маркийн бетонд	М300(В25) ба түүнээс дээш маркийн бетонд																																	
Дайрга	2	1																																	
Хайрга, буталсан хайрга	1	1																																	
Шигшүүрийн нүхний хэмжээ, мм	Шигшүүр дээрхи нийлбэр үлдэц, жингийн хувиар																																		
5	0																																		
2,5	0-20																																		
1,25	15-45																																		
0,63	35-70																																		
0,315	70-90																																		

				0,14	90-100																									
				0,14 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хэсэг	10-0																									
				Ширхэгийн модуль	2,1-3,25																									
